

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
2025 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2025 оны 09 сарын 29

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1,8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын бүртгэлийн байгууллагын 24 нэгж болох Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн улсын бүртгэлийн газар, 21 аймгийн орон нутгийн Улсын бүртгэлийн хэлтэс, төрийн өмчит компани болох “Төрийн үнэт цаас хэвлэл” ТӨДХХК нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлтийг хүлээн авч нэгтгэлийг танилцуулж байна.

Нэг. 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дүгнэлт

№	Нэгжийн нэр		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Үнийн дүн /мян.төг/	Тоо	Үнийн дүн /мян.төг/	Тоо	Үнийн дүн /мян.төг/
1	Архангай	Өөрчлөлтгүй			1	3.328,0		
2	Баян-Өлгий	Өөрчлөлтгүй						
3	Баянхонгор	Өөрчлөлтгүй			2	28.047,9		
4	Булган	Өөрчлөлтгүй			1	1.471,0	1	1.876,5
5	Говь-Алтай	Түүвэрт орсон						
6	Говьсүмбэр	Өөрчлөлтгүй					1	-
7	Дархан-Уул	Өөрчлөлтгүй	1	7.062,8				
8	Дорноговь	Түүвэрт орсон						
9	Дорнод	Өөрчлөлтгүй						
10	Дундговь	Түүвэрт орсон						
11	Завхан	Түүвэрт орсон						
12	Орхон	Өөрчлөлтгүй			1	5.431,5	2	-
13	Өвөрхангай	Өөрчлөлтгүй			1	8.959,3		
14	Өмнөговь	Өөрчлөлтгүй			1	1.059,2	3	-
15	Сэлэнгэ	Өөрчлөлтгүй			2	10.764,3		
16	Сүхбаатар	Түүвэрт орсон						
17	Төв	Өөрчлөлтгүй					4	-
18	Увс	Өөрчлөлтгүй						
19	Ховд	Өөрчлөлтгүй					1	13.463,3
20	Хөвсгөл	Түүвэрт орсон					1	-

21	Хэнтий	Түүвэрт орсон						
22	НУБГ	Өөрчлөлтгүй			4	112.343,5	1	28.150,0
23	УБЕГ	Өөрчлөлтгүй			5	46.161,2	6	3.325,7
24	Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК	Хязгаарлалттай	1	36.420,0	7	34.033.835,3	2	
25	УБЕГ /нэгтгэсэн/	Хязгаарлалттай			3	3.285.964,8		
НИЙТ			2	43.482,8	28	37.537.366,0	22	46.815,5

Улсын бүртгэлийн ерөнхий газрын буюу төсвийн төвлөрүүлэн захирагчийн нийт 24 нэгж, нэгтгэсэн 1 буюу нийт 25 нэгжийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг нэгтгэхэд Улсын бүртгэлийн 23 нэгж нь “Өөрчлөлтгүй”, “Төрийн үнэт цаас хэвлэл” ТӨДХХК нь “Хязгаарлалттай” дүгнэлт тус тус авсан.

Монгол Улсын ерөнхий аудиторов А/124 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам” болон “Санхүүгийн тайлангийн аудитын хамрах хүрээ, аудит хийх шатлал болон хэлбэр” заалтын 5.3.2-г баримталж "...санхүүгийн тайлангийн үе шатны ажлыг хэсэгчлэн хийж, аудит хийсэн санхүүгийн тайлангийн талаар бие даасан дүгнэлт гаргалгүй, аудитын дүнг дээд шатны байгууллагад хийсэн аудитын дүнд оруулж тайлагнах аудит” хэсгийн үндэслэн 7 хэлтэст түүврийн аудит хийгдсэн.

Хоёр. Аудитын акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт

Улсын бүртгэлийн байгууллагад Төрийн аудитын байгууллагаас нийт 52 алдаа, зөрчлийн биелүүлсэн байдлыг хүснэгтээр илэрхийлбэл:

№	Нэгжийн нэр	Зөрчлийн утга	Зөрчлийн дүн /мян.төг/	Хэрэгжүүлсэн байдал	Биелэлт хувь
ТӨЛБӨРИЙН АКТ					
1	Дархан-Уул	Тайлант онд байгууллагын албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдэл цалинг илүү олгосон.	7.062.8	Актын биелэлтийг Дархан аймгийн Да.Хүү, торгуулийн орлого 100190000988 тоот дансанд 2025.05.26-ны өдөр 7.062.800.00 төгрөгийг шилжүүлсэн.	100 хувь
2	Төрийн үнэт цаас хэвлэлт ТӨДХХК	Тус байгууллагын 2 ажилтан 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр эрх барих этгээдийн мэдээлэлд бүртгэгдэж, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	36.420,0	Буруутай албан хаагчдад актыг танилцуулж, цалингаас суутган, төлбөрийн актыг 2025 оны 06 сарын 30-ны өдөр 36.419.999,4	100 хувь

		болсон боловч тайлант онд үндсэн ажилтнаар ажиллаж цалин давхардуулан авсан.		төгрөгийг УАГ-ын 10900000601 тоот дансанд тушааж барагдуулсан.	
НИЙТ АКТЫН ДҮН			43.483.0		100 хувь

№	Нэгжийн нэр	Зөрчлийн утга	Зөрчлийн дүн /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Биелэлт хувь
АЛБАН ШААРДЛАГА					
1.	Архангай	Цалингийн сангаас урамшуулал олгосон.	3.328,0	Архангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2025.03.24-ний өдрийн 11/230 тоот албан бичгээр Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн.	100 хувь
2.	Баянхонгор	Нэг удаагийн буцалтгүй мөнгөн тэтгэмжийг цалингийн зардлаас олгосон байна.	1.452,0	Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2025.02.27-ны өдрийн 13/213 тоот албан бичгээр Баянхонгор аймгийн Төрийн аудитын газарт хүргүүлсэн.	100 хувь
		Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд 3 гүйлгээг мэдээлээгүй байна.	26.595,9		100 хувь
3.	Булган	Цалингийн сангаас нягтлан бодогчид 1 сарын үндсэн цалингаар балансын урамшуулал олгосон байна.	1.471,0	Булган аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2025.05.30-ны өдрийн 14/392 тоот албан бичгээр Булган аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн.	100 хувь
4.	Орхон	Орхон аймгийн ЗДТГ-ын урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна.	5.431,5	Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2025.05.30-ны өдрийн 22/826 тоот албан бичгээр Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн.	100 хувь
5.	Өвөрхангай	Тусгай зориулалтын материалын анхан шатны баримт	8.959,3	Өвөрхангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2025.05.28-ны өдрийн	100 хувь

		бүрдэл дутуу байна.		23/300 албан бичгээр Өвөрхангай аймгийн Төрийн аудитын газарт хүргүүлсэн	
6.	Өмнөговь	Өмнөговь аймгийн шагнагдсан урамшууллыг цалингийн сангаас олгож, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	1.059,2	Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2025.03.25-ны өдрийн 24/199 албан бичгээр Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн.	100 хувь
7.	Сэлэнгэ	Тайлант онд багаж, техник хэрэгслийн зардлаас урсгал засварын зардалд байна.	206,4	Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2025.06.12-ны өдрийн 26/414 албан бичгээр Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн. Сахилгын хариуцлага тооцох албан шаардлагыг 2025 оны 06 сарын 05-ны өдрийн Б/08 тоот хэлтсийн даргын тушалаалаар нийт ажилтанд зарлах хэлбэрээр "нээлттэй сануулах сахилгын шийтгэл" ногдуулж ажилласан.	100 хувь
		нийгмийн даатгалын шимтгэлийг давхардуулан шилжүүлж, авлага үүсгэсэн байна.	10.557,9		100 хувь
8.	НУБГ	Үйлчилгээний орлогын буцаалт хийх журам байхгүй, мөнгө шилжүүлэхэд нэгдүгээр гарын үсэг эзэмшигчийн цохолт хийдэггүй.	75.272,8	Нийслэлийн улсын бүртгэлийн газрын даргын 2025.04.30-ны өдрийн 10/259 тоот албан бичгээр Ниямазон аудит ХХК-д хүргүүлсэн. Дахин давтан гаргахгүй хууль тогтоомжийг хэрэгжүүлэн анхаарч ажиллана.	100 хувь
		БЗД-ийн улсын бүртгэлийн хэлтэст үнэ төлбөргүй өгсөн шийдвэргүйгээр данснаас хассан.	30.000,0		100 хувь
		Дүүргийн хэлтсүүдэд хангамжийн материалыг тушаал шийдвэргүйгээр данснаас хассан.	7.070,7		100 хувь

9.	УБЕГ	Гадаад харилцааны яамтай үнэт цаас болон сонгуулийн санал хураах тоног төхөөрөмж, эцэст үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.	-	Гадаад харилцааны яамтай үнэт цаас, бусад хүлээлцсэн тоног төхөөрөмж компьютерийг балансад бүртгэсэн эсэхэд хяналт тавих, харилцан баталгаажуулж хамтран ажиллах талаар 2025 оны 05 сарын 02-ны өдрийн 1/6051 дугаар албан бичгээр ГХЯ-ны Санхүү, эдийн засгийн хэлтсийн даргад хүргүүлж ажилласан. Үнэт цаас, маягтын тайланг 2025 оны эхний улирлын байдлаар гарган, тооцоо нийлж ажилласан. Үндсэн хөрөнгө бараа материалын тайланг 2025 оны 08 сарын 27-ны өдөр хүлээлгэн өгсөн байдлаар биелэлтийг ханган ажиллаж байна.	100 хувь
		Гадаад паспортыг хэвлэх болон бэлдэц бэлтгэх үед үүссэн алдаа, үнэт цаасны дутагдлыг хэн нь хариуцах нь тодорхойгүй.	-	Үнэт цаас хэвлэлтийн алдаа, дутагдал, илүү, дутуу хэвлэхгүй байх үлдэгдлийг захиалагчийн хяналтанд дор устгах талаар гэрээндээ тусгаагүй байсныг байгууллагын 2025 оны худалдан авах ажиллагаагаар шалгарч гэрээ байгуулсан 3 байгууллагад арга хэмжээ авч ажиллах, хариуг ирүүлэх талаар 2025 оны 09 сарын 02-ны өдрийн албан бичгээр тус тус хүргүүлж ажилласан (Хариуг хавсаргасан болно)	95 хувь
		Төрийн үйлчилгээний албан тушаалын цалинг ЗГ тогтоолоос цалингийн зөрүүг бодож олгосон байна.	13.123,2	Тус цалингийн доод хэмжээг нэмэгдүүлж болохгүй гэсэн хориглох хууль, журам байхгүй тул Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалтад заасан эрхийн хүрээнд ерөнхий газрын даргын 2024.04.08-ны Б/222	100 хувь

				дугаар тушаалын дагуу төрийн үйлчилгээний цалин хөлсийг шинэчлэн тогтоосон.	
		Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй	21.170,0	ТБОНӨХБАҮХАТ хуулийн худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулахаар заасныг ханган ажиллаж байгаа бөгөөд 2025 оны худалдан авалт хуулийн дагуу алдаа зөрчилгүй ажиллаж байна.	100 хувь
		Үндэсний дата төвөөс балансаас баланст шилжүүлэн авсан үнэ бүхий 138000 ширхэг ашиглалтаас гарсан ТҮЦ машины лавлагааны маягт бүртгэлгүй байна.	11.868,0	Үндэсний дата төвийн 2021 оны 01/179 дугаар албан бичгийн дагуу 11,868,041.0 төгрөгийн 138.000 ширхэг ТҮЦ машины лавлагааг санхүүгийн дансанд үнэ төлбөргүйгээр сонгуулийн үйл ажиллагаанд ашиглана гэж авч, 2021 оны 10 сарын 04-ны өдөр санхүүгийн программд тусгасан байсан (нотлох баримтыг хавсаргасан). Гэвч ашиглахгүй байгаа тул байгууллагын Өмч хамгаалах байнгийн зөвлөл"-ийн хурлаар хэлэлцүүлэх шаардлагын хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хурлаар акталж, данснаас хасч, устгах талаар танилцуулж, дүгнэлт, хурлын шийдвэрийг даргын зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлэхээр хүлээгдэж байна.	100 хувь
10.	Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК		34.033.835,3	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн заалтыг баримтлан ажиллаж байгаа бөгөөд 2025 онд	80,7

				хуулийг зөрчин худалдан авалт хийгдээгүй болно. Цаашид уг зөрчлийг давтан гаргахгүй ажиллана.(7 төрлийн албан шаардлагын дундаж биелэлтээр тооцсон болно)	
ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АЛБАН ШААРДЛАГЫН ДҮН			34.251.401,2		96,3 хувь
1.	УБЕГ /нэгтгэл/	Тайлант онд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд 3,172,284.8 мянган төгрөгийн богино хугацаат өр төлбөр үүсгэж, барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.	3.172.284,8	<u>ТҮЦХ ТӨДХХК-ийн хувьд:</u> 1. Жордан топпен трейд ХХК болон Мигасон ХХК-ийн түрээсийн төлбөрт нийт 2.706.397.404 төгрөгийн өр төлбөртэй байсныг 2025 оны 04-р сард бүрэн барагдуулсан. 2.Цалингийн өглөг буюу 12 сарын нийт ажилчдын сүүл цалингийн өр 68.003.742 төгрөгийг 2025 оны 01-р сард цалинг бүрэн олгосон. 3.Татварын өр 330.781.396.90 төгрөгийг 2025 оны 04-р сард бүрэн барагдуулсан. <u>УБЕГ-ын хувьд:</u> 1.ХХОАТ-ын нийт өр 31.333.928,2 төгрөгийг 2025 оны 01-р сард цалинг бүрэн олгосон. 2.НДШ-өр 1.285.768,97 төгрөгийг 2025 оны 02-р сард бүрэн барагдуулсан. 3.Ашиглалтын, шуудан холбоо, бичиг хэргийн зардлын 29.103.149,0 төгрөгийн өр үүссэнийг 1-р улиралд багтааж барагдуулсан.	100 хувь
		Аудитаар бараа материалын тооллого хийхэд Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-д хүлээлгэн өгсөн,	113.680,0	УБЕГ-ын Иргэний бүртгэлийн газарт хадгалагдаж байсан 1664 ширхэг бэлдцийг 2025 оны 04 сарын 30-ны өдөр холбогдох албан	100 хувь

		бодитоор оршин байхгүй байна.		тушаалтныг байлцуулан хүлээлцсэн.	
		УБЕГ-ын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 27,906,593.6 мянган төгрөгийн 43 зөрчил илэрсэн нь төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүйтэй холбоотой байна.	-	Улсын бүртгэлийн ерөнхий газрын аудитаар илэрсэн 27.9 тэрбум төгрөгийн зөрчлийг биелүүлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар БТДШГазар нь 2025 оны 04 сарын 30-ны өдөр 4 зорилт, 38 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж байна. 2025 оны 01 сарын 10-ны өдрийн 7/959 дугаар албан бичгээр ТҮЦХ ТӨДХХК, 2025 оны 01 сарын 17-ны өдрийн 7/912 дугаар албан бичгээр болон НУБГ болон орон нутагт зөрчлийг хугацаанд биелүүлэх, гаргасан зөрчлийг давтан гаргахгүй байх талаар хугацаатай зөвлөмж хүргүүлсэн. -2025 оны 05 сарын 21-нд Орон нутагт 7/7088, 05 сарын 21-нд ТҮЦХ ТӨДХХК-д 7/7089, 2025 оны 08 сарын 22-нд 7/10086 дугаар албан бичгээр тус тус зөвлөмж хүргүүлэн биелэлтийг авахаар ажиллаж байна. -Улсын бүртгэлийн ерөнхий газрын аудитаар илэрсэн 27.9 тэрбум төгрөгийн зөрчлийг биелүүлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар БТДШГазар нь 2025 оны 04 сарын 30-ны өдөр 4 зорилт, 35 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж, биелэлт 98,1 хувьтай байна.	98,1 хувь

ТТЗ-ЫН АЛБАН ШААРДЛАГЫН ДҮН	3.285.964,8		99,4 хувь
-----------------------------	-------------	--	--------------

Төлбөрийн 1 актыг 100 хувь, албан шаардлагын биелэлт 10 төсвийн захирагчийн хувьд 96,3 хувь, нэгтгэлийн хувьд 99,4 хувь, зөвлөмжийн биелэлтийг 18 төсвийн захирагчийн хувьд 100,0 хувийг хугацаанд нь буюу 2025 оны 09 сарын 05-ны өдөр тус тус хүргүүлж ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын нийт 24 нэгжээс 23 нэгж нь “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт авч, аудитын дүгнэлтээр нийт 52 зөрчил илэрсэн ба үүнээс 2 нэгжид 2 акт, 10 нэгжид 28 албан шаардлага, 9 нэгжид 22 зөвлөмжийг тус тус ирүүлснийг нэгтгэн, шинжлэхэд:

№	Алдаа, зөрчлийн ангилал	Зөрчлийн тоо	Мөнгөн дүн /мян.төг/
1	Төсвийн тухай хууль	22	97,817.6
2	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	9	3,277,050.9
3	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль	6	30,293,890.6
4	Компанийн тухай хууль	3	3,762,434.1
5	Шилэн дансны тухай хууль	3	26,595.9
6	Ахмад настны тухай хууль	1	-
7	ТӨБЗГ-ын тогтоол	1	-
8	Төрийн аудитын тухай хууль	1	-
9	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль	1	28,150.0
10	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль	1	141,725.1
11	Улсын бүртгэлийн ерөнхий хууль	1	-
12	ХНХСайдын журам	1	-
13	Хөдөлмөрийн тухай хууль	1	-
14	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль	1	-
НИЙТ		52	37,627,664.3

Гурав. Нэгжүүдэд хүргүүлсэн зөвлөмж:

Нэгжүүдэд нийтлэг илэрсэн зөрчил нь:

- Орон нутагт ажилласны нэмэгдэл цалинг илүү олгосон;
- Цалингийн сангаас урамшуулал, тусламж олгосон;
- Төрийн үйлчилгээний албан хаагчдад ЗГ-ын тогтоолоос илүү дүнгээр олгосон;
- Эдийн засгийн ангилал зөрчиж төсвийн зарцуулалт хийсэн;
- Ур чадварын нэмэгдлийг тушаалгүй олгодог;
- Өр, авлага үүсгэж хяналтгүй ажилласан;
- Тендер, сонгон шалгаруулалт зарлахгүйгээр худалдан авсан;
- Төрийн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаа хоцроосон;
- Үндсэн хөрөнгийн бүртгэл, данснаас хасалт зөрчилтэй;
- Шилэн дансанд мэдээллийг дутуу байршуулсан;

2025 оны 01 сарын 10-ны өдрийн 7/959 дугаар албан бичгээр ТҮЦХ ТӨДХХК, 2025 оны 01 сарын 17-ны өдрийн 7/912 дугаар албан бичгээр НУБГ болон орон нутагт илэрсэн зөрчлийг хугацаанд биелүүлэх талаар хүргүүлсэн, мөн 2025 оны 05 сарын 21-ны 7/7088 дугаар албан бичгээр 21 аймагт, мөн 7/7089 дугаар албан бичгээр ТҮЦХ ТӨДХХК-д тус тус илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар болон энэхүү чиглэлийг өмнөх онуудад хүргүүлж байсан ч ижил төрлийн байдлаар давтан гарсаар байгаа тул хугацаатай үүрэг даалгаврыг өгч ажиллалаа.

Дөрөв. Цаашид дотоод аудитын чиглэлээр хийгдэх ажил

Нэг.Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны дотоод аудитын төлөвлөгөөний дагуу акт, албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэн биелэлтийг нотлох баримтын хамт хугацаанд нь хүргүүлэхэд хяналт тавин ажиллаж, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар онцгойлон ажиллана.

Хоёр.Орон нутгийн улсын бүртгэлийн хэлтсүүдээс санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажилтан, албан хаагчдын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, тасралтгүй боловсролоор хангах сургалтын сэдэв, саналыг хүлээн авч сургалт зохион байгуулахаар 2025 оны 4 улиралд хийгдэх ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллана.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР